



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 14 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

### Г Эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дурэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодъ даатгал” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Ширчин овогтой Сүхбаатарыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллахыг Ш.Сүхбаатарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН